

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ТАНИЛЦУУЛГА**

2025.02.15

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго:

Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийлээ.

Үйл ажиллагаанд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А-87 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ыг тус тус үндэслэл болгов.

Хоёр. Танилцуулга:

2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:

Салбарын хяналтын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилтын 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 16 арга хэмжээ, 90 хувийн 23, 70 хувийн 5, 30 хувийн 1, тасарсан буюу 0 хувийн 1 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ **86.5** хувь байна. Хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт1/										
№	Зорилт	Нийт	Үүнээс /хувиар/						ХБ	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
Нийт		48	16	23	5	2	1	1	-	86.5

2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжилт

Тус газарт Засгийн газрын тогтоолоор 3, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр 4 үүрэг даалгавар өгөгдсөн ба 2024 оны жилийн эцсийн байдлаар үүрэг даалгаврын хэрэгжилт 95.7 хувийн үнэлгээтэй байна.

/Хүснэгт 2/

№	Нэр	Нийт	Үүнээс /хувиар/				ХБ	Үнэлгээ /хувиар/
			100	70	30	0		
1	Засгийн газрын тогтоол	3	3	-	-	-	-	100.0
2	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	3	1	-	-	-	92.5
Нийт		7	6	1	-	-	-	95.7

2.3. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт:

Салбарын хяналтын газарт сайдын тушаалаар өгөгдсөн 9 үүрэг даалгаврын хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 5, 70 хувийн 2, 30 хувийн 2 арга хэмжээний дундаж хэрэгжилт **77.8** хувь байна.

/Хүснэгт 3/

Нийт	Үүнээс /хувиар/					Үнэлгээ
	100	70	30	0	Хугацаа болоогүй	
9	5	2	2	-	-	77.8

2.4. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тус газарт 22 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн 16, 70 хувийн 3, 30 3 арга хэмжээний хэрэгжилт **86.4** хувьтай байна. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын үнэлгээг доорх хүснэгтээр үзүүлэв.

/Хүснэгт 4/

Нийт	Үүнээс /хувиар/					Үнэлгээ
	100	70	30	0	Хугацаа болоогүй	
22	16	3	3	-	-	86.4

3. Үнэлгээ:

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”, Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар батлагдсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх журам”-ын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар тус газрын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, Сайдын болон

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг 4 үзүүлэлтээр дүгнэв. Доорх хүснэгтээр үнэлгээг нэгтгэж үзүүллээ.

/Хүснэгт 5/

№	Арга хэмжээний нэр	Нийт	Үүнээс /хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	48	16	23	5	2	1	1	-	86.5
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	7	6	-	1	-	-	-	-	95.7
3	Сайдын тушаал	9	5	-	2	-	2	-	-	77.8
4	ТНБД-ын тушаал	22	16	-	3	-	3	-	-	86.4
Нийт		86	42	23	11	2	6	1	-	86.3

3.1 Салбарын хяналтын газрын үйл ажиллагааг 2024 оны жилийн эцсийн байдлаар дүгнэхэд 4 чиглэлийн 86 арга хэмжээний дундаж үнэлгээ 86.3 хувьтай байна.

3.2. Салбарын хяналтын газрын үйл ажиллагааны онцлог нь тогтмол байнгын давтагдах шинжтэй байдаг. Мөн тус газар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх арга хэмжээг 2024 оны III-IV улиралд төлөвлөсөн ч зарим хяналт шалгалтыг төлөвлөсөн хугацаанд хийж амжаагүй байна.

4. Санал, зөвлөмж:

4.1. Тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахад хүрэх түвшин болон хэрэгжүүлэх хугацааг зөв төлөвлөх, зорилтод түвшинг бүрэн хангах, салбарын хэмжээнд гарсан зөрчил дутагдлыг бүрэн арилгах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр анхаарч ажиллах шаардлагатай байна.

4.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд тус газарт хамаарах үүрэг даалгаврыг ХШҮДАГ-тай хамтран тодорхойлох, үүрэг даалгаврын хэрэгжилтийг тогтмол заасан хугацаанд шинэчлэн тайлагнаж, ажиллах;

4.3. Төрийн жинхэнэ албан хаагч бүр өөрийн хариуцсан ажлын биелэлтийг заасан хугацаанд, товч бөгөөд тоо баримттай, бүрэн тайлагнаж ажиллахыг тус тус зөвлөж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

№	Арга хэмжээний нэр	Нийт	Үүнээс /хувиар/						Хугацаа болоогүй	Үнэлгээ /хувиар/
			100	90	70	50	30	0		
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	48	16	23	5	2	1	1	-	86.5
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр	7	6	-	1	-	-	-	-	95.7
3	Сайдын тушаал	9	5	-	2	-	2	-	-	77.8
4	ТНБД-ын тушаал	22	16	-	3	-	3	-	-	86.4
Нийт		86	42	23	11	2	6	1	-	86.3

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГРАФИК

